



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 03 сарын 25-ны
өдрийн 6186 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 83


Улаанбаатар хот


“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд
хувийн дугаар олгох журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д. БАЯРСАЙХАН



1518800143



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ХУВИЙН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувийн дугаар (цаашид “хувийн дугаар” гэх) нь 10 оронтой тоогоор илэрхийлсэн код байх ба эхний орон нь бүртгэх байгууллагыг, хоёр дахь орон нь хувь хүн, хуулийн этгээдийн аль нь болохыг, гурав болон дөрөв дэх орон нь бүртгэсэн байгууллагын байршлыг, тав болон зургаа дахь орон нь бүртгэл олгосон оны сүүлийн хоёр оронг, долоогоос арав дахь орон нь бүртгэсэн эрх бүхий байгууллагын бүртгэлийн дугаарыг илэрхийлнэ.

1.3.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарын хувийн дугаарыг тухайн хуулийн этгээдийн энэ журмын 1.2-т заасан үндсэн хувийн дугаараас хойш гурван оронгоор илэрхийлнэ.

Хоёр.Хувийн дугаар олгох

2.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэх байгууллага нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаарыг олгож, бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийнэ.

2.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд бүртгэлийн дугаарт өөрчлөлт оруулахгүй.

2.3.Хувийн дугаарын сүүлийн 4 орныг олгохдоо шинэ он эхлэх бүр эхнээс нь дугаарлах бөгөөд хуулийн этгээд буюу “барьцаалан зээлдүүлэх газар”, хувь хүн буюу “зээлийн үйлчилгээ” эрхлэх этгээдийг харгалзахгүй дараалуулан дугаарлана.

2.4.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарын хувийн дугаарыг олгохдоо огноо үл хамааран тухайн хуулийн этгээдийг салбар байгуулах тухай бүр дараалуулан дугаарлана.

2.5.Хүчингүй болсон хувийн дугаарыг дахин олгохгүй.

--oOo--

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ын хавсралт

№	ДЭЛГЭРЭНГҮЙ	ТОВЧЛОЛ
1	Санхүүгийн зохицуулах хороо	1
	Аймаг/нийслэл-ийн Засаг дарга	2
2	Хувь хүн	1
	Хуулийн этгээд	2
3	Улаанбаатар хот	11
	Дорнод	21
	Сүхбаатар	22
	Хэнтий	23
	Төв	41
	Говьсүмбэр	42
	Сэлэнгэ	43
	Дорноговь	44
	Дархан-Уул	45
	Өмнөговь	46
	Дундговь	48
	Орхон	61
	Өвөрхангай	62
	Булган	63
	Баянхонгор	64
	Архангай	65
	Хөвсгөл	67
	Завхан	81
	Говь-Алтай	82
	Баян-Өлгий	83
Ховд	84	
Увс	85	

Жишээ нь: “1211220001” гэсэн хувийн дугаар нь Санхүүгийн зохицуулах хорооноос Барьцаалан зээлдүүлэх газрыг Улаанбаатар хотод 2022 онд 1 дугаарт бүртгэсэн гэх утгыг илэрхийлнэ.

Аймаг нийслэлийн кодыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн [2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор баталсан Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг](#) баримтлан дугаарлана.

Салбарын хувьд: 1211220001-001 гэж дугаарлана.